| Улсын бүртгэлд анх бүртгэгдсэн он, сар, өдөр | <b>0000-00-00</b>                                                                                                    | Жишээлбэл: 20161001 буюу 2016 оны 10 сарын 01                                                                                                                                                                                                                                                                                                               |
| Шинжилгээний төрөлд суурилсан ангилал        | <b>Bi</b><br><b>Cc</b><br><b>He</b><br><b>Im</b><br><b>Ih</b><br><br><b>Mb</b><br><b>Mi</b><br><b>Pt</b><br><b>O</b> | <b>Bi</b> -Biochemistry-Биохими<br><b>Cc</b> -Clinical chemistry-Клиникийн хими<br><b>He</b> - Hematology-Гематологи<br><b>Im</b> - Immunology -Иммунологи<br><b>Ih</b> -Immunohematology-Иммуногематологи<br><b>Mb</b> -Molecular biology-Молекулбиологи<br><b>Mi</b> -Microbiology-Микробиологи<br><b>Pt</b> -Pathology-Патологи<br><b>O</b> -Other-Бусад |
| Тухайн оношлуурын дугаар                     | <b>00000</b>                                                                                                         | 00050; 00051; г.м 5 цифрээр                                                                                                                                                                                                                                                                                                                                 |

5.4. БИБ-ний бүртгэлийн дугаар нь тухайн БИБ-ний эх үүсвэр, Монгол Улсад бүртгэгдсэн огноо, үсгэн тэмдэглэгээ, БИБ-ний хувийн дугаарыг агуулна.

5.5. Бүртгэлд бүртгэгдсэн БИБ-нд бүртгэлийн дугаар олгохдоо нэр томъёоны дараах товчлолыг ашиглана. Үүнд: F-анх бүртгэгдсэн он, сар, өдөр-Үсгэн товчлол-бүтээгдэхүүний дугаар (F20161001Supp00050)

|           | Товчлол              | Тайлбар                                                             |
|-----------|----------------------|---------------------------------------------------------------------|
| Эх үүсвэр | <b>F</b><br><b>L</b> | Foreign=Гадаад буюу импортын БИБ;<br>Local=Үндэсний үйлдвэрийн БИБ; |

|                                              |            |                                                |
|----------------------------------------------|------------|------------------------------------------------|
| Улсын бүртгэлд анх бүртгэгдсэн он, сар, өдөр | 0000-00-00 | Жишээлбэл: 201601001 буюу 2016 оны 10 сарын 01 |
| Үсгэн тэмдэглэл                              | Supp       | Supplement-Биологийн идэвхт бүтээгдэхүүн       |
| Тухайн БИБ-ний дугаар                        | 00000      | 00050; 00051; г.м 5 цифрээр                    |

5.6. Бүртгэлийн гэрчилгээг нэг хувь үйлдэж, бүртгүүлэгч байгууллагад олгох ба хуулбарыг нь ажлын албанд архивлана.

5.7. Эмийн бүртгэлийн гэрчилгээнд ХЭЗ-ийн дарга, оношлуурын бүртгэлийн гэрчилгээнд БОСЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ХЭЗ-ийн дарга, БИБ-нийн бүртгэлийн гэрчилгээнд БИБСЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ХЭЗ-ийн дарга гарын үсэг зурж, ЭМЯ-ны тэмдгээр баталгаажуулна.

Зургаа. Бүртгэлийн хугацааг сунгах, өөрчлөх, хүчингүй болгох

6.1. Тухайн эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-нийг анх бүртгүүлсэн байгууллага бүртгэлийн өөрчлөлт, хугацаа сунгуулахтай холбоотой үйлдвэрлэгчээс ирүүлсэн баримт бичиг, албан хүсэлтийг ажлын албанд хүлээлгэн өгнө.

6.2. Эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ бүртгүүлэгч бүртгэлийн хүчинтэй хугацаа дуусахаас хоёр сарын өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаргана.

6.3. Эмийн бүртгэлийн хугацааг сунгуулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 6.3.1. Бүртгэлийн хугацааг сунгуулах тухай үйлдвэрлэгчийн албан хүсэлт;
- 6.3.2. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн эм, эмийн түүхий эдийн хугацааг сунгуулах өргөдлийн эх хувь;
- 6.3.3. ДЭМБ-ын жишгийн дагуу эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификатын эх хувь эсхүл албан ёсоор баталгаажуулсан хувь (эмийн түүхий эдэд хамаарахгүй);
- 6.3.4. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
- 6.3.5. Ажлын албатай гэрээтэй итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
- 6.3.6. Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар батлуулсан хэрэглэх зааврын хувь (эмийн түүхий эдэд хамаарахгүй);
- 6.3.7. Хугацаа дууссан бүртгэлийн гэрчилгээний эх хувь;
- 6.3.8. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт загвар зураг (эмийг олгох нөхцөл, бүртгэлийн дугаар бичих талбарыг заасан байх, эмийн түүхий эдэд хамаарахгүй);
- 6.3.9. Бүртгүүлэгч байгууллагаас үндэсний үйлдвэрт үйлдвэрлэгддэг эмэнд хийсэн зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүртээмжийн судалгаа (эмийн түүхий эдэд хамаарахгүй);

6.4. Оношлуурын бүртгэлийн хугацааг сунгуулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 6.4.1. Бүртгэлийн хугацааг сунгуулах албан хүсэлт;
- 6.4.2. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн оношлуурын хугацааг сунгуулах өргөдлийн эх хувь;

- 6.4.3. Үйлдвэрлэгчийн чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ (ISO13485)-ний хуулбар (үйлдвэрлэгч баталгаажуулсан байх);
- 6.4.4. Оношлуурыг шинжилсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, загвар дээжийг туршсан дүнгүүд;
- 6.4.5. Анхдагч болон хоёрдогч савлалт (анх бүртгүүлсэн болон одоогийн)-ын өнгөт загвар зураг;
- 6.4.6. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан хэрэглэх заавар (БОСЗ-өөр баталгаажуулсан байх);
- 6.4.7. Хугацаа дууссан бүртгэлийн гэрчилгээний эх хувь;

6.5. БИБ-ний хугацааг сунгуулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 6.5.1. Бүртгэлийн хугацааг сунгуулах тухай үйлдвэрлэгчийн албан хүсэлт;
- 6.5.2. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн БИБ-ний хугацааг сунгуулах өргөдлийн эх хувь;
- 6.5.3. БИБ-ний аюулгүй байдлын талаарх мэдээлэл;
- 6.5.4. БИБ-ний хэрэглэх заавар (БИБСЗ-өөр баталгаажуулсан байх);
- 6.5.5. Хугацаа дууссан бүртгэлийн гэрчилгээний эх хувь;
- 6.5.6. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт загвар зураг;
- 6.5.7. Ажлын албатай гэрээтэй итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;

6.6. Ажлын алба нь бүтээгдэхүүний бүртгэлийн хугацаа сунгахтай холбоотойгоор эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын мэдээллийн тайланг Эм судлалын салбар зөвлөлөөс, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас, зар сурталчилгааны зөрчлийн талаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас холбогдох санал, дүгнэлтийг улирал бүр авч ХЭЗ-д танилцуулна.

6.7. Үйлдвэрлэгчээс тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи, судалгаа шинжилгээний үр дүн, эмийн эмчилгээний үр нөлөө болон зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн эмийн чанарыг сайжруулах зорилгоор эцсийн бүтээгдэхүүнд хийж буй өөрчлөлтүүдийг ажлын албанд мэдээлж, ХЭЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ. Үүнд:

- 6.7.1. Анхдагч, хоёрдогч савлалтын өөрчлөлт (хаяглалт, савлалтын загвар, хэмжээ, материал өөрчлөгдөх, бар код, лого, галограмм, цуврал, бүртгэлийн дугаар, үйлдвэрлэгдсэн болон дуусах хугацааны мэдээллийн байрлалыг өөрчлөх, анхааруулга, сэрэмжлүүлэг, эсрэг заалт, гаж нөлөөний мэдээллийг тодотгох, хэрэглэгчид зориулсан мэдээллийг өөрчлөх, зураг, холбогдох мэдээлэл зэргийг нэмэх, хасах);
- 6.7.2. Бүх төрлийн шахмал, капсул, лаа зэрэг эмийн хэлбэр дээрх бичиглэл, таних тэмдэг, бэх зэргийг өөрчлөх;
- 6.7.3. Нэмэлт савлалт;
- 6.7.4. Хэрэглэх зааврын өөрчлөлт (эмийн хэрэглэх зааврын хувьд шинээр өвчний заалт нэмэгдээгүй тохиолдолд);
- 6.7.5. Эмийг олгох нөхцлийн өөрчлөлт;
- 6.7.6. Эцсийн бүтээгдэхүүн болон үндсэн үйлчлэгч бодисын шинжилгээний арга, аргачлалын өөрчлөлт;
- 6.7.7. Тогтвортой байдлын судалгааны дүн, хадгалах хугацаа, хадгалах нөхцлийн өөрчлөлт;
- 6.7.8. Тухайн үйлдвэрлэгчийн нэр, хаягийн өөрчлөлт (тухайн үйлдвэрлэгчийн нэр эсхүл хаяг өөрчлөгдсөн, гарал үүслийн улс өөрчлөгдөөгүй тохиолдолд);
- 6.7.9. Лиценз эзэмшигчийн нэрийн өөрчлөлт;

- 6.7.10.Туслах болон будагч бодисын найрлага, тунгийн өөрчлөлт (олон улсад зөвшөөрөгдсөн бодисоор солих г.м);
- 6.7.11.Эмийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх үйл ажиллагааны өөрчлөлт;
- 6.7.12.Эмийн бүтээгдэхүүний худалдааны нэрийн өөрчлөлт (үндсэн үйлчлэгч болон туслах бодис, түүний тун хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд);

6.8. Бүртгэлд өөрчлөлт оруулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 6.8.1. Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай үйлдвэрлэгчийн албан хүсэлт;
- 6.8.2. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах өргөдлийн эх хувь;
- 6.8.3. Өөрчлөлттэй холбоотой дэлгэрэнгүй тайлбар, холбогдох баримт бичиг (анхдагч ба хоёрдогч савлалт өөрчлөгдсөн бол хуучин болон шинэ загварын өнгөт, дэлгэмэл зургийг харьцуулан хавсаргах, эцсийн бүтээгдэхүүн, үндсэн үйлчлэгч бодисын шинжилгээний аргачлалд өөрчлөлт орсон бол ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг хавсаргах гэх мэт);
- 6.8.4. Тогтвортой байдлын судалгааны дүн, хадгалах хугацаа, хадгалах нөхцлийн өөрчлөлтийн хувьд шинжээчийн дүгнэлт;
- 6.8.5. Худалдааны нэрийн өөрчлөлтийн хувьд бүртгэлийн бүрэн баримт бичиг бүрдүүлнэ.

6.9. ХЭЗ, салбар зөвлөлөөс дараах тохиолдолд эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ний бүртгэлийг хүчингүй болгоно. Үүнд:

- 6.9.1. Гарал үүслийн улсын бүртгэлээс хасагдсан болон хэрэглэхээ больсон эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ;
- 6.9.2. Бүртгүүлэгч болон үйлдвэрлэгчээс бүртгэлийг хүчингүй болгох албан хүсэлт ирүүлсэн;
- 6.9.3. Тандалт судалгаагаар тухайн бүтээгдэхүүн чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй болохыг итгэмжлэгдсэн эсхүл лавлагаа лабораторийн шинжилгээ болон бусад баримт бичиг, судалгааны дүн, мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр нотлогдсон;
- 6.9.4. Хуурамч баримт бичиг бүрдүүлэн бүртгүүлэх, бүртгэлийг өөрчлөх, хугацаа сунгуулахтай холбоотой шийдвэр гаргуулсан болохыг тогтоосон шинжээч, хууль, хяналтын байгууллагын дүгнэлт;
- 6.9.5. Тухайн бүтээгдэхүүний чанар, идэвх, аюулгүй байдлын талаар эрүүл мэндийн байгууллага, иргэдээс ирсэн гомдлын мөрөөр хууль, мэргэжлийн хяналтын байгууллага шалган шийдвэрлэсний дагуу бүртгэлээс хасах санал ирүүлсэн;
- 6.9.6. Бүтээгдэхүүний чанар болон ноцтой гаж нөлөөний улмаас хүний амь эрсэдсэн, удаан хугацаагаар эмчлүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй болсон, хөдөлмөрийн чадвараа алдсан нь холбогдох хууль, хяналтын байгууллагын шалгалтаар нотлогдсон;
- 6.9.7. Эмчилгээ оношлогооны стандарт, заавар, удирдамж, зөвлөмжөөс хасагдсан, хэрэглэхээ больсон;
- 6.9.8. ДЭМБ болон тухайн улсын эм, хүнсний зохицуулалтын эрх бүхий байгууллагаас тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэхийг хориглосон тухай гаргасан шийдвэр;

6.10. Бүртгэлээс хассан болон зах зээлээс эргүүлэн татах шийдвэр гарсан тохиолдолд хурлын тэмдэглэл гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор холбогдох хууль, хяналтын байгууллагад мэдээлж, цахим мэдээллийн санд өөрчлөлт оруулна.

6.11. Бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-нд бүртгэлийн дараах тандалт судалгаа хийх шаардлагатай бол ХЭЗ-өөс ажлын удирдамжийг баталж, тандалт судалгаа хийх багийн бүрэлдэхүүнийг томилно.

6.12. Бүтээгдэхүүний бүртгэлийг сунгуулах хүсэлтийг энэхүү журмын 6.2-т заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд бүртгэлийн хугацаа дууссан өдрөөс эхлэн бүртгэлгүйд тооцож ажлын алба бүртгэлээс хасагдсан тэмдэглэгээг мэдээний санд хийнэ.

#### Долоо. Бусад

7.1. ХЭЗ болон салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ний бүртгэлийн баримт бичгийг албан бичиг, хэргийн стандартын дагуу баталгаажуулан, ажлын алба нь холбогдох зөвлөл, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад ажлын 5 хоногийн өмнө ирүүлэн хурлын төлөвлөгөөнд тусгуулна.

7.2. Бүртгүүлэгч байгууллага бүртгүүлсэн бүтээгдэхүүнийхээ чанар, аюулгүй байдалд тавьсан хяналт, судалгааны тайлан, дүнгийн талаарх үнэн зөв, бодит мэдээллээр ХЭЗ, салбар зөвлөлийг ханган ажиллана.

7.3. Бүртгүүлэгч байгууллага бүртгэлийн хураамжийг нэхэмжилсэн хугацаанд барагдуулах бөгөөд шинжээчийн дүгнэлт гарсан болон шинжилгээ эхэлснээс хойш бүртгүүлэх хүсэлтийг буцаахгүй.

7.4. Бүртгэлийн хүчинтэй хугацаа бүхий улсын бүртгэлийн гэрчилгээг бүртгүүлэгч байгууллага хүлээн аваагүй тохиолдолд Монгол Улсад импортлох, түгээх, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэхийг хориглоно.

7.5. ХЭЗ, салбар зөвлөлөөс бүртгэлээс хасч, зах зээлээс эргүүлэн татах шийдвэр гарсан бүтээгдэхүүнийг зах зээлээс эргүүлэн татах зардлыг бүртгүүлэгч тал хариуцна.

7.6. Тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад хүний эрүүл мэнд, амь нас, эдийн засгийг хохироосон нь хууль хяналтын байгууллагаар тогтоогдсон бол учирсан хохирлыг тухайн үйлдвэрлэгч, нийлүүлэгч тал хариуцаж барагдуулна.

#### Найм. Бүртгэлийн баримт бичгийг хадгалах, ашиглах

8.1 Бүртгэсэн эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ний мэдээний сан, бүртгэлийн архивын баримт бичгийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг ажлын алба хариуцаж, “Архивын тухай хууль”-ийн дагуу хадгална.

8.2 Архивын баримт бичгийг зөвхөн албан хэрэгцээнд зориулсан байгууллагын “Архивын баримт ашиглах, лавлагаа хуулбар олгох” журмын дагуу ашиглана.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
....сарын .... өдрийн .... дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

ЭМ, ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, ОНОШЛУУР, БИОЛОГИЙН ИДЭВХТ  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БҮРТГЭЛИЙН ТӨЛБӨР, ЗАРДЛЫН ЖИШИГ,

## ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн төлбөр, зардлын жишиг

1.1. Бүртгэлд эм, эмийн түүхий эд, БИБ, оношлуур бүртгэх үйл ажиллагааны хөлс (цаашид “бүртгэлийн төлбөр” гэх)-ийг өмчийн хэлбэрийг үл харгалзан улсын төсөвт төлнө.

1.2. Эм, эмийн түүхий эд, БИБ, оношлуурын бүртгэлийн төлбөрийг бүртгүүлэгч тал хариуцах ба тухайн бүртээгдэхүүний бүртгэлийн асуудлыг ХЭЗ болон ХЭЗ-ийн БОСЗ, БИБСЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээс өмнө улсын төсөвт төлсөн байна.

1.3. Гадаад валютаар хийгдэх төлбөрийг ам.доллараар хийх ба тухайн өдрийн Монголбанкны ханшаар тооцно. Гадаад шилжүүлгийн шимтгэлийг төлөгч байгууллага хариуцна.

1.4. Бүртгэлийн төлбөр нь буцаан төлөх нөхцөлгүйгээр дараах хэмжээтэй байна. Үүнд:

| №  | Бүртгэлийн төрөл                                                         | Төлбөрийн хэмжээ /төг/ |         |
|----|--------------------------------------------------------------------------|------------------------|---------|
|    |                                                                          | Бүртгэх                | Сунгах  |
| 1  | Импортын эмийн түргэвчилсэн бүртгэл                                      | 900,000                | 600,000 |
| 2  | Импортын эмийн энгийн бүртгэл                                            | 800,000                | 600,000 |
| 3  | Үндэсний үйлдвэрийн эмийн бүртгэл                                        | 400,000                | 250,000 |
| 4  | Эмийн түүхий эдийн бүртгэл                                               | 500,000                | 300,000 |
| 5  | 4 ба түүнээс дээш найрлагатай нийлмэл найрлагатай импортын эмийн бүртгэл | 1,600,000              | 600,000 |
| 6  | Үндэсний үйлдвэрт үйлдвэрлэгддэг импортын эмийн бүртгэл                  | 1,600,000              | 600,000 |
| 7  | ХЭЗ-өөс бодлогоор бүртгэхээр төлөвлөсөн эмийн бүртгэл                    | 300,000                | 600,000 |
| 8  | Импортын БИБ-ний бүртгэл                                                 | 800,000                | 600,000 |
| 9  | Үндэсний үйлдвэрийн БИБ-ний бүртгэл                                      | 400,000                | 250,000 |
| 10 | Импортын оношлуурын бүртгэл                                              | 300,000                | 250,000 |
| 11 | Үндэсний үйлдвэрийн оношлуурын бүртгэл                                   | 200,000                | 150,000 |
| 12 | Бүртгэлийн өөрчлөлт эм, БИБ                                              | 300,000                | -       |
| 13 | Бүртгэлийн өөрчлөлт оношлуур                                             | 200,000                | -       |

1.5. Бүртгэлийн шинжээч ажиллуулах, Хүний эмийн зөвлөл болон түүний салбар зөвлөлийн гишүүдэд хуралд оролцсон цагаар тооцон ажлын хөлс олгоход дараах жишгийг баримтална.

| № | Үйл ажиллагааны төрөл                                              | Хэмжих нэгж  | Үнэ /төг/ |
|---|--------------------------------------------------------------------|--------------|-----------|
| 1 | ХЭЗ, салбар зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс                         | 1 хүн/цаг    | 20,000    |
| 2 | Фармакопейн хорооны гишүүдийн ажлын хөлс                           | 1 хүн/цаг    | 20,000    |
| 3 | ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс          | 1 хүн/цаг    | 20,000    |
| 4 | Эмийн мэдээлэл сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс | 1 хүн/цаг    | 20,000    |
| 5 | Эм зүй, эмнэлзүйн шинжээчийн ажлын хөлс                            | 1 шинжээч/эм | 150,000   |

|   |                                 |                        |         |
|---|---------------------------------|------------------------|---------|
| 6 | Онош зүйн шинжээчийн ажлын хөлс | 1 шинжээч/<br>оношлуур | 100,000 |
| 7 | БИБ-ний шинжээчийн ажлын хөлс   | 1 шинжээч/БИБ          | 100,000 |
| 8 | GMP-ийн шинжээчийн ажлын хөлс   | 1 шинжээч/үйлдвэр      | 100,000 |
| 9 | Хурал, үйл ажиллагааны зардал   | 1 хүн                  | 5000    |

Хоёр. Эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн төлбөрийн зарцуулалт

2.1. Бүртгэлийн төлбөрийг Ажлын албаны төсөвт зардалд тусган батлуулж дараах үйл ажиллагаанд зарцуулна. Үүнд:

- 2.1.1. Гадны болон үндэсний үйлдвэртэй танилцах, судлах, эрсдлийн үнэлгээ хийх, үйлдвэрлэгчийн талаар лавлагаа авах;
- 2.1.2. Эмийн зах зээлийн болон идэвх, чанар, аюулгүй байдлын тандалт судалгааг тогтмол явуулах;
- 2.1.3. Тандалт судалгаа явуулах үйл ажиллагаанд шаардлагатай мэргэжилтэн, үнэлгээний багийг гэрээгээр ажиллуулах зардал;
- 2.1.4. Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх үйл ажиллагаатай холбогдох үйл ажиллагааны зардал;
- 2.1.5. Эмийн гаж нөлөөг мэдээлэх, мэдээлэл солилцох олон улсын хяналтын төвийн гишүүнчлэлийн төлбөр (Упсалла олон улсын хяналтын төв);
- 2.1.6. Бүртгэлийн шинжээчдийн ажлын хөлс;
- 2.1.7. Шинжээчид болон бүртгүүлэгч байгууллагад зориулсан сургалтын зардал;
- 2.1.8. Бүртгэлийн гэрчилгээ хэвлүүлэх;
- 2.1.9. GMP-ийн батламжийн гэрчилгээ хэвлүүлэх;
- 2.1.10. Шаардлагатай зарим үйл ажиллагаанд олон улсын зөвлөх, шинжээч ажиллуулах;
- 2.1.11. Олон улсын үзэсгэлэн яармаг, хурал зөвлөгөөн, богино хугацааны сургалт семинар, танилцах аялалд Хүний эмийн зөвлөлийн гишүүд, холбогдох мэргэжилтнүүд, шинжээчдийг оролцуулах;
- 2.1.12. Эм зүйн салбарын хууль эрхзүй, зохицуулалт, хэрэгжилтэд ашиглах ном, товхимол, гарын авлага, эмийн мэдээлэл сэтгүүл, эм зүйн үзүүлэлтийг хэвлүүлэх;
- 2.1.13. Эмийн зохистой хэрэглээний мэдээлэл, сургалт сурталчилгаа;
- 2.1.14. Мэдээний сангийн тогтвортой үйл ажиллагаа, бар коджуулах, шинэчлэл хийх зардал;
- 2.1.15. Мэргэжлийн гадаад, дотоод хэвлэл, ном товхимол, мэдээлэл, захиалах, интернэт эрх авах;
- 2.1.16. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангахад шаардагдах зардал;
- 2.1.17. ХЭЗ болон түүний салбар зөвлөл, Фармакопейн хороо, Эм зүй, Эм судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн хурал, үйл ажиллагааны зардал;
- 2.1.18. Журмын хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа;
- 2.1.19. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын эмзүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад үйл ажиллагаа;
- 2.1.20. Үндэсний фармакопей боловсруулах, хэвлүүлэх, баяжилт хийх;

2.2. Ажлын алба улсын бүртгэлийн төлбөрийн орлого, зарлагын тайланг ажлын албанаас жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын ЭЭХҮХ-т тайлагнаж, Хүний эмийн зөвлөлийн хуралд танилцуулна.



--oOo--

Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
.... сарын .... өдрийн .... дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

#### **А. ИМПОРТЫН ЭМ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

## APPLICATION FORM FOR REGISTRATION OF IMPORTED MEDICINES

Өргөдлийн хэлбэр (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)

Type of application (check the applicable box)

- ☐ Шинээр бүртгүүлэх  
New registration
- ☐ Бүртгэлд өөрчлөлт оруулах  
Changes to an existing registration
- ☐ Хугацаа сунгуулах  
Renewal of registration

Өргөдлийн 1-р хэсгээс бусдыг Англи хэл дээр эм үйлдвэрлэгч эсхүл лиценз эзэмшигч бөглөнө.

(To be filled in English by manufacturer or license holder except Part I)

|                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|-----------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| I ХЭСЭГ.<br><b>PART I</b>                                       | <b>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.</b><br>Өргөдөл гаргагч нь тухайн үйлдвэр эсхүллиценз эзэмшигчийг Монголд төлөөлөх хууль ёсны эрхтэй төлөөлөгчийн газар эсхүл тухайн үйлдвэр эсхүл лиценз эзэмшигчтэй гэрээ бүхий Монгол Улсын эм ханган нийлүүлэх байгууллага байна.<br><b>APPLICANT'S INFORMATION</b><br>The applicant shall be an legal representative of a foreign manufacturer or license holder in Mongolia, or a Mongolian wholesaler, who has a contract with the manufacturer on registration of listed medicine(s). |
| Бүртгүүлэгч байгууллагын нэр<br>Name of organization            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Бүртгүүлэгч байгууллагын хаяг<br>Business address               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Шуудангийн хаяг<br>Postal address                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Утасны дугаар<br>Telephone number                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Факсын дугаар<br>Fax number                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Е-мэйл хаяг<br>E-mail address                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Харилцах хүн, утасны дугаар<br>Contact person, telephone number |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| II ХЭСЭГ.<br><b>PART II</b>                                     | <b>ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b><br><b>MANUFACTURER INFORMATION</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| Үйлдвэрлэгчийн нэр<br>Name of manufacturer                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Үйлдвэрлэгчийн хаяг<br>Manufacturing site address               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Шуудангийн хаяг<br>Postal address                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Утасны дугаар<br>Telephone number                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Факсын дугаар<br>Fax number                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Вэб хаяг<br>Web address                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |

|                                                                                                                          |                                                        |             |                        |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------|-------------|------------------------|
| Харилцах хүн<br>Contact person                                                                                           |                                                        |             |                        |
| Е-мэйл хаяг<br>E-mail address                                                                                            |                                                        |             |                        |
| Лиценз эзэмшигчийн нэр<br>Licence holder's name                                                                          |                                                        |             |                        |
| Лиценз эзэмшигчийн хаяг<br>Licence holder's address                                                                      |                                                        |             |                        |
| III ХЭСЭГ.<br>PART III                                                                                                   | БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ<br>PRODUCT INFORMATION |             |                        |
| Эмийн худалдааны нэршил<br>Proprietary name (trade name)                                                                 |                                                        |             |                        |
| Эмийн ерөнхий нэршил<br>(хэрвээ байгаа бол)<br>Approved generic name(s)<br>(use the INN, if any)                         |                                                        |             |                        |
| Үйлчлэгч бодисын нэр, тун хэмжээ<br>Name and strength of active ingredients                                              |                                                        |             |                        |
| Нэр<br>Name                                                                                                              | Тунхэмжээ<br>Strength                                  | Нэр<br>Name | Тунхэмжээ<br>Strength  |
| 1.                                                                                                                       |                                                        | 4.          |                        |
| 2.                                                                                                                       |                                                        | 5.          |                        |
| 3.                                                                                                                       |                                                        | 6.          |                        |
| Туслах бодисын нэр тун хэмжээ<br>Name and strength of inactive ingredients                                               |                                                        |             |                        |
| Нэр<br>Name                                                                                                              | Тун хэмжээ<br>Strength                                 | Нэр<br>Name | Тун хэмжээ<br>Strength |
| 1.                                                                                                                       |                                                        | 5.          |                        |
| 2.                                                                                                                       |                                                        | 6.          |                        |
| 3.                                                                                                                       |                                                        | 7.          |                        |
| 4.                                                                                                                       |                                                        | 8.          |                        |
| Эмийн хэлбэр<br>Dosage form                                                                                              |                                                        |             |                        |
| Хадгалах нөхцөл<br>Storage condition                                                                                     |                                                        |             |                        |
| Хүчинтэй хугацаа<br>Shelf life                                                                                           |                                                        |             |                        |
| Шошгоны монитор<br>(Зөвхөн вакцинд хамаарна)<br>The vaccine vial monitor<br>(Related only for vaccine)                   |                                                        |             |                        |
| Савлалтын хэлбэр<br>Primary packaging                                                                                    |                                                        |             |                        |
| Савлалтын хэмжээ (нэгж ба бөөнөөр савласан)<br>Packing size (unit and bulk package)                                      |                                                        |             |                        |
| Олгох нөхцөл (жороор, жоргүй, эмнэлгийн нөхцөлд)<br>Dispensing category<br>(prescription, OTC or for hospital treatment) |                                                        |             |                        |
| Хэрэглэх арга зам<br>Route of administration                                                                             |                                                        |             |                        |
| Хүний биеийн бүтэц<br>эмчилгээнд суурилсан ангилал                                                                       |                                                        |             |                        |

|                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-------------|------------------|
| Anatomical therapeutic classification                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Фармакологийн ангилал<br>Pharmacological classification                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Гадаад байдал<br>Description                                                                                                                                         | Өнгө/Color                                                                                                                                                                                                                                                                    | Хэлбэр/Form | Хэмжээ/Size | Бүрхүүл /Coating |
|                                                                                                                                                                      | Бусад/Other description                                                                                                                                                                                                                                                       |             |             |                  |
| Хэрэглэх заалт<br>Indications                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Хориглох заалт<br>Contraindications                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Мэдээлэгдсэн гаж нөлөө<br>List of reported side effects                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Өртөг шингэсэн бөөний үнэ<br>Wholesale Price                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| IV ХЭСЭГ.<br>PART IV                                                                                                                                                 | БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ<br>REGISTRATION INFORMATION                                                                                                                                                                                                                       |             |             |                  |
| Үйлдвэрлэсэн улсын нэр<br>Country of origin                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Үйлдвэрлэгч эсхүллиценз<br>эзэмшигчийн улсад<br>бүртгэсэн дугаар<br>Registration number<br>in country of manufacturer or<br>license holder                           |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Үйлдвэрлэгч эсхүл лиценз<br>эзэмшигчийн улсад<br>бүртгэсэн огноо<br>Date of registration in country<br>of manufacturer or license<br>holder                          | (dd/mm/yy)                                                                                                                                                                                                                                                                    |             |             |                  |
| Тухайн бүтээгдэхүүнийг<br>бүртгэсэн улсын тоо, нэр<br>Number and name of<br>countries, this product was<br>registered                                                |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| V ХЭСЭГ.<br>PART V                                                                                                                                                   | Чанарын удирдлагын тогтолцоотой олон улсын хангамжийн байгууллагаас эм бүртгүүлэх нөхцөлд энэ хэсгийг бөглөнө.<br>This part is required to submit a request for medicine registration from the International Supply Chain Management System with a quality management system. |             |             |                  |
| Чанарын удирдлагын тогтолцоотой олон улсын хангамжийн байгууллагын нэр<br>Name of the International Supply Chain Management System with a quality management system. |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Хаяг<br>Site address                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Шуудангийн хаяг<br>Postal address                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Утасны дугаар<br>Telephone number                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Факсын дугаар<br>Fax number                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Вэб хаяг<br>Web address                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |
| Харилцах хүн<br>Contact person                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                               |             |             |                  |

|                               |  |
|-------------------------------|--|
| E-мэйл хаяг<br>E-mail address |  |
|-------------------------------|--|

I (authorized person) .....declare that the particulars given in this application are true and correct.

Date.....

Authorized signature.....

...../ажлын албаны нэр/

...../name of the institution/

Хаяг: .....

Address: .....

Шуудангийн хайрцаг: .....

POB: .....

Факс: .....

Fax: .....

## **Б. ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ЭМ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдлийн хэлбэр (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)

- ☐ Шинээр бүртгүүлэх
- ☐ Бүртгэлд өөрчлөлт оруулах
- ☐ Хугацаа сунгуулах

|                                                         |  |                                                                                                                    |        |        |            |
